



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 26-ны өдөр

Дугаар А/08

Эрдэнэт

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үед нэн шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээг шилжүүлэн ажиллах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5, эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4.1-10.4.5, 11.3.4, Коронавируст(Ковид-19) халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Эрүүл мэндийн Сайдын 2020 оны А/562, 2021 оны А/04 дүгээр тушаалуудыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Коронавируст (Ковид-19) халдварын цар тахлын үед Бүсийн оношилгоо эмчилгээний төв халдварын голомт болж үйл ажиллагааг түр зогсоосон үед эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй явуулах, нэн шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээг хувийн хэвшлийн эмнэгүүдэд шилжүүлэх зураглалыг нэгдүгээр, эмнэлгүүдэд нэмэлтээр ажиллах хүний нөөцийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эмнэлгийн тусламж үйлчилгээг шилжүүлэхтэй холбоотой шаардлагатай багаж тоног төхөөрөмжийг байршуулах, бэлэн байдлыг хангуулан ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагуудын захирал болон Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.

3. Коронавируст (Ковид-19) халдварын цар тахлын үед эмнэлэг дотор халдвар гарсан үед хөл хорионы дэглэмийг тогтоосон хугацаанаас цуцлах хугацаа хүртэл эмнэлгийн доторх үйл ажиллагааны зохион байгуулалтын зураглалыг гаргах, хэсэгчлэн хаах, хөдөлгөөний урсгалыг зогсоох, аль болох богино хугацаанд халдварын голомтыг задлах, хоол хүнс, эм, тарианы нөөцийг бэлтгэх, тасралгүй хангах, их цэвэрлэгээ хийх, голомтын болон эцсийн халдваргүйтэлийг хийлгэх ажлуудыг зохион байгуулахыг Бүсийн оношилгоо эмчилгээний захирал /Б.Батсүх/-д, хувийн хэвшлийн хэвтэн эмчлүүлэх ор бүхий эмнэлгүүдийн дарга нарт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс Яаралтай гамшгийн үеийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Уртнасан/-д үүрэг болгосугай.

5. Уг тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны А/53 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай .

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




My doc. EMG-iin dargiin tushaal

Эрүүл мэндийн газрын даргын
2021 оны 01 дүгээр сарын
26-ний өдрийн 1/01 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ КОРОНАВИРУСТ(КОВИД-19) ХАЛДВАРЫН
ГОЛОМТ БОЛСОН ҮЕД НЭН ШААРДЛАГАТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ХУВИЙН ХЭВШЛИЙН
ЭМНЭЛГҮҮДЭД ШИЛЖҮҮЛЭХ ЗУРАГЛАЛ

БОЗТ-ИЙН ТАСГУУД	НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ ХИЙЖ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮРГЭЛЖҮҮЛЭХ ЭМНЭЛГҮҮД	Хариуцах мэргэжилтэн
Төрөх тасаг, эрүүл нярай, эмэгтэйчүүд	Баянөндөр мед Нэгдсэн эмнэлэг	ЭХТҮХМэргэжилтэн П.Хишгээ СТҮХМэргэжилтэн А.Баярхүү
Мэс засал, гэмтэл, хагалгааны нэгдсэн тасаг	Медипас төрөлжсөн төв эмнэлэг	ЯГҮТҮХМэргэжилтэн Б.Уртнасан
ЯТЭЭМ мэдээгүйжүүлэг, яаралтай тусламжийн тасаг	Медипас төрөлжсөн төв эмнэлэг	ЯГҮТҮХМэргэжилтэн Б.Уртнасан
Амбулаторийн тасаг	Шинэ эрин төрөлжсөн мэргэшлийн клиник	ЯГҮТҮХМэргэжилтэн Б.Уртнасан
Хүүхэд, эмгэг нярайн тасаг	Ачит хувийн хэвшлийн ортой эмнэлэг	ЭХТҮХМэргэжилтэн П.Хишгээ
Дотрын тасаг	Бадархундага хувийн хэвшлийн ортой эмнэлэг	ЯГҮТҮХМэргэжилтэн Б.Уртнасан
Мэдрэлийн тасаг	Тайхар хувийн хэвшлийн ортой эмнэлэг	ЯГҮТҮХМэргэжилтэн Б.Уртнасан
Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ	Мөнхийн үйлс хувийн хэвшлийн ортой эмнэлэг	СТҮХМэргэжилтэн А.Баярхүү
Ковидыг эмчлэх эмнэлэг/хөнгөн, хүндэвтэр/	Талын булаг, Очир увидас хувийн хэвшлийн ортой эмнэлгүүд-70 ор	ЯГҮТҮХМэргэжилтэн Б.Уртнасан СТҮХМэргэжилтэн А.Баярхүү
Дүрс оношилгоо	Баянөндөр мед Нэгдсэн эмнэлэг, Медипас төрөлжсөн төв эмнэлэг	ЯГҮТҮХМэргэжилтэн Б.Уртнасан
Бактерлогийн тасаг	Медипас төрөлжсөн төв эмнэлэг	СТҮХМэргэжилтэн А.Баярхүү
Клиник лаборатори	Баянөндөр мед Нэгдсэн эмнэлэг, Медипас төрөлжсөн төв эмнэлэг	СТҮХМэргэжилтэн А.Баярхүү
Ариутгалын тасаг	Медипас төрөлжсөн төв эмнэлэг	СТҮХМэргэжилтэн А.Баярхүү
Вируслогийн тасаг	Медипас төрөлжсөн төв эмнэлэг	СТҮХМэргэжилтэн А.Баярхүү
Түргэн тусламж	Эмнэлэг сувиллын цогцолбор, Медипас төрөлжсөн төв эмнэлэг	ЯГҮТҮХМэргэжилтэн Б.Уртнасан

Эрүүл мэндийн газрын даргын
2021 оны 01 дүгээр сарын
26-ний өдрийн А/108 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



ЭМНЭЛГҮҮДЭД ШААРДЛАГАТАЙ НЭМЭЛТЭЭР АЖИЛЛУУЛАХ ХҮНИЙ
НӨӨЦИЙН ХУВААРЬ

№	Эмнэлгийн нэрс	Шаардлагатай хүний нөөц	Нэмэлтээр ажиллуулах хүний нөөцийн хуваарь
1	Медипас төрөлжсөн төв эмнэлэг	Гэмтлийн их эмч, сувилагч	БОЭТ-ийн гэмтлийн их эмч -1, сувилагч -1
2	Баянөндөр мед Нэгдсэн эмнэлэг	Эх барих эмэгтэйчүүдийн эмч , нярайн эмч, сувилагч	1. БОЭТ-төрөх тасгийн эх барих эмэгтэйчүүдийн их эмч-3, эх баригч бага эмч -3, нярайн их эмч 2, нярайн сувилагч -3 2. Хувийн хэвшлийн эх барих эмэгтэйчүүдийн их эмч -2, эх баригч бага эмч-2
3	Ачит хувийн хэвшлийн ортой эмнэлэг	Хүүхдийн их эмч, Нярайн их эмч, сувилагч	1. БОЭТ-ийн хүүхдийн тасгийн их эмч-2, сувилагч 2 2. Хувийн хэвшлийн хүүхдийн клиникийн их эмч-1, сувилагч -1 3. Нярайн их эмч 2, нярайн сувилагч -2, хувийн хэвшлийн нярайн их эмч-1, сувилагч 1
4	Мөнхийн үйлс хувийн хэвшлийн ортой эмнэлэг	Хөнгөвчлөхийн их эмч, сувилагч	1. БОЭТ-ийн хөнгөвчлөхийн их эмч-1, сувилагч-1
5	Бадархундага хувийн хэвшлийн ортой эмнэлэг	Дотрын их эмч /зүрх судас/ Сувилагч	БОЭТ-ийн дотрын их эмч, сувилагч -2
6	Тайхар хувийн хэвшлийн ортой эмнэлэг	Мэдрэлийн их эмч , сувилагч	БОЭТ-ийн мэдрэлийн их эмч, сувилагч -2